

# International Theatre Institute ITI

## World Organization for the Performing Arts



**2024-03-27 Дэлхийн театрын өдрийн захиа**

**Захиа бичигч: Жон ФОССЕ, Норвеги улс**  
Норвегийн зохиолч, жүжгийн зохиолч

Монгол (Орчуулга)

---

### **Дэлхийн театрын өдөр 2024 Жон ФОССЕ-гийн захиа**

#### **Урлаг бол энх тайван**

Хүн бүр онцгой хэдий ч бусадтайгаа ч бас адил. Мэдээж хүн бүр гадаад байдал, харагдах үзэмжээрээ бүгд нэг нэгээсээ ялгаатай, энэ бол сайн бас зүй ёсны хэрэг. Гэвч бидний дотор, дотоод ертөнцөд зөвхөн өөрт л хамаарах ямар нэгэн зүйл байдаг ба тэр бол зөвхөн тэр л хүнд хамаарах онцгой юм. Үүнийг бид сүнс эсвэл оюун санаа гэж нэрлэж болно. Эс бөгөөс огт үгээр оноож нэрлэхгүй зүгээр л байгаагаар нь орхиж бас болно.

Гэхдээ бид хэдий нэг нэгнээсээ тэс өөр ялгаатай боловч бас өөр хоорондоо ижил төстэй. Дэлхийн хаана байгаагаас үл хамааран хүмүүс бүгд суурь мөн чанараараа адилхан, үүнд бидний ярьдаг хэл, арьсны өнгө, тэр бүү хэл үсний өнгө ямар байх нь огт хамаагүй, бид бүгд адил төстэй.

Энэ магадгүй логик зөрчлийн нэг хэлбэр байх: бид бүгд гайхалтай адилхан ба нэгэн зэрэг мөн тэс өөр хүмүүс. Магадгүй бие болоод оюун санааг холбож буй тэр холбоост хүн мөн чанартаа логик зөрчилтэй байж болох юм – бид газар дэлхийтэй хамгийн нягт холбоотой бодит биет оршихуй болон материаллаг, газар дэлхийн хязгаарыг даван гарсан ямар нэгэн сүнслэг оршихуйг хоёуланг нь нэгэн зэрэг өөртөө агуулж байдаг байх.

Урлаг, сайн урлаг нь туйлын өвөрмөц, мөн нийтлэг гайхамшигтай аргаар удирдаж байдаг. Энэ нь бидэнд ялгаатай зүйлсийг – юу харь болохыг ойлгуулдаг, үүнийг бид нийтлэг шинж гэж хэлж болох юм. Ингэснээр урлаг нь хэл, газар зүйн бүс болон улс орны хил хязгаарыг гэтлэн гарч нэвтэрч чаддаг. Урлаг нь хүн бүрийн доторх хувь чанаруудыг гарган ирж нэгтгэхийн сацуу бүлэг хүмүүс, тухайлбал улс үндэстэн бүрийн онцлог мөн чанарыг илтгэн таниулдаг.

Урлаг нь ялгааг үгүйсгэн юм болгоныг ижилсгэх замаар бус, харин ч эсрэгээрээ юу биднээс өөр ялгаатай, юу харь эсвэл гадных болохыг илчлэн харуулах замаар ажилладаг. Бүх сайн урлаг яг үүнийг л агуулж байдаг: ямар нэгэн харь зүйл, бидний бүрэн гүйцэд ойлгож ухаарч чадахгүй хэрнээ ямар нэгэн байдлаар бас тухайн мөчид ойлгож ухаарч байдаг ямар нэгэн зүйлийг ямагт агуулдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь ямар нэгэн учир битүүлэг, нууцлаг зүйлийг агуулж байдаг. Биднийг гайхшруулж бас бидний хязгаарыг тэлж байдаг

ба ингэснээр урлаг нь биднийг өөрөө удирдан бодит байдлаас ангижирч оюун санааны өөр түвшинд хүрэхэд хүргэж байх ёстой юм.

Эсрэг тэсрэг зүйлсийг нэгтгэх өөр ямар илүү арга зам байдгийг би мэдэхгүй. Үүний эсрэг хандлага түгээмэл ба дэлхий дээр дэндүү ойр ойрхон болж буй зэвсэгт мөргөлдөөн, технологийн хүмүүнлэг бус нээлтийн үр дүнд гарт ойр болсон сүйтгэн устгах зэвсэг хэрэглэн харийн, өвөрмөц, өөр ялгаатай гэсэн болгоноо устгахаар улайран тэмцэлдэх хандлага хаа сайгүй байгааг бид харж байна. Дэлхий дээр терроризм байна. Дайн дажин ч байна. Учир нь хүмүүст ч гэсэн амьтны шинж байдаг ба танил бус зүйлийг гайхалтай нууцлаг зүйл гэж хүлээн авахын оронд хүн амьтны зөнгөөрөө үүнийг өөрийнх нь оршин байхад аюул учруулах зүйл гэж үздэг.

Бидний харж чадах өвөрмөц байдал – ялгаатай байдал – үүнээс болж үгүй болж, зөвхөн нийтээр ижил төстэй байх байдал түгээмэл болж байна. Учир нь бид ялгаатай байдлыг устгавал зохих аюул гэж үзэх болж. Жишээлбэл, шашны эсвэл улс төрийн үзэл сурталд ямар нэгэн ялгаатай зүйл харагдах даруйд түүнийг ялан дийлж устгах ёстой зүйл гэж харж хандах болсон байна.

Дайн гэдэг бол бидний дотоодод гүн нуугдан оршиж байдаг тэмцэл: өвөрмөц зүйл. Энэ мөн урлагийн эсрэг тэмцэл, бидний дотоодод гүн орших урлагийн эсрэг тэмцэл юм.

Би энд театр эсвэл жүжгийн зохиол бичих тухайд бус харин урлагийн тухайд ерөнхийд нь ярьж байна, яагаад гэвэл бүх сайн урлаг өөрийн мөн чанартаа нэг л зүйлийг тойрон хувиран хөгжиж байдаг: туйлын өвөрмөц, туйлын тодорхой зүйлийг авч нийтлэг болгодог гэдгийг би түрүүн хэлсэн. Өвөрмөц зүйлийг нийтлэг болгон уран сайхнаар илэрхийлэх нь түүний өвөрмөц чанарыг үгүй хийхэд бус харин дөвийлгөн гаргаж бидний үл мэдэх харь юмст онцгойрон ялгарах боломжийг олгох юм.

Дайн ба энх эсрэг тэсрэгтэй адил дайн ба урлаг бол эсрэг тэсрэг зүйлс – энэ ийм л энгийн. Урлаг бол энх тайван.

Орчуулсан: Наянбаатарын Болороо